



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, , “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10,220,000.00 (арван сая хоёр зуун хорин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Түмэнбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000884

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн
435 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, дугаар	Үйлдсэн/ Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин, УАЗ-22069-033, улсын дугаар УБЗ 70-22, арлын дугаар 80450478	2006/2008	10,220,000.00	10,220,000.00	0.00	1,500,000
	Дүн		10,220,000.00	10,220,000.00	-	1,500,000.00
			(арван сая хоёр зуун хорин мянга)	(арван сая хоёр зуун хорин мянга)		(нэг сая таван зуун мянга)